



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2020 оны 05 сарын 14 өдөр

Дугаар A/81

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Зүлэгний үр, бордоо худалдан авах /Ховд, Жаргалант сум/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Д.Ариунбилэг -Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүдэд: Б.Далайбаяр -Эрүүл мэндийн газрын эдийн засагч  
Б.Батсүх -Төрийн бус байгууллагын төлөөлөл  
Б.Сайнзаяа - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн

дарга: Э.Цолмон

-Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ш.Нохойжав/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Э.Цолмон /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

2020 тг А/81-Сн  
02 00450